



Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага(ОУХБ)-ын Зөвлөмж

# COVID-19 ба хөдөлмөрийн ертөнц: Үр нөлөө, хариу арга хэмжээ

2020 оны 3 дугаар сарын 18

Энэхүү зөвлөмжид COVID-19 цар тахал хөдөлмөрийн ертөнцөд хэрхэн нөлөөлж байгаа талаар ОУХБ-ын урьдчилсан үнэлгээнд үндэслэн нөхцөл байдлыг даван туулахад туслах бодлогын хувилбарууд болон авч болох шийдвэртэй, шуурхай арга хэмжээг санал болгож байна.

Нөхцөл байдал маш хурдтай өөрчлөгдөж байгаа тул энэ талаарх шинэ баримт, мэдээллийн дагуу бид уг зөвлөмжөө шинэчлэн гаргах болно.

Мэдээлэл авахыг хүсвэл [newsroom@ilo.org](mailto:newsroom@ilo.org) хаягаар холбогдоно уу.

Хөдөлмөрийн ертөнцөд үзүүлж буй COVID-19 хямралын эсрэг авч буй арга хэмжээний талаар цаг үеийн мэдээллийг дараах вэб сайтаас үзээрэй.

▶ [ilo.org/global/topics/coronavirus](https://ilo.org/global/topics/coronavirus)



## 1. Өнөөгийн нөхцөл байдал: Яагаад хөдөлмөрийн зах зээлд илүү анхаарал хандуулах ёстой вэ?

Аль хэдийн 148 орны 170,000 орчим хүнд халдварлаж, нас баралтын тохиолдол 6,500 гаруйд хүрээд буй COVID-19 цар тахал<sup>1</sup> дэлхийн хүн амын ихэнх хувьд нөлөөлж мэдэхээр байна. Зарим тооцооллоос харахад цар тахал дэлхийн хүн амын 40-70 хувийг хамрах төлөвтэй.<sup>2</sup>

Энэхүү хямрал нь эдийн засаг, хөдөлмөрийн зах зээлийг цочроож эхэлсэн бөгөөд зөвхөн нийлүүлэлт (бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээ) төдийгүй эрэлтэд (хэрэглээ, хөрөнгө оруулалтад) нөлөөлж байна. Эхлээд Азийн орнуудын бүтээгдэхүүн үйлдвэрлэлд нөлөөлж байсан бол цаашлаад дэлхийн нийлүүлэлтийн сүлжээнд нөлөөлж эхэллээ. Бизнесийн хэмжээнээс үл хамааран бүх төрлийн бизнес, ялангуяа агаарын тээвэр, аялал жуулчлалын салбарын орлого буурах, дампуурах, ажлын байраа алдах зэргээр ихээхэн бэрхшээлтэй тулгарч байна. Ялангуяа жижиг, дунд үйлдвэрүүд (ЖДҮ) үйл ажиллагаагаа хэвийн явуулахад хүндрэлтэй болж байна. Улс хоорондын хөдөлгөөнийг зогсоож, хил хаах, хөл хорио тогтоох зэрэг арга хэмжээ авсны улмаас олон ажилчин, тэр дундаа албан бус эдийн засагт ажиллаж байгаа, эсвэл тохиолдлын чанартай ажил эрхэлдэг хүмүүсийн хувьд ажилдаа ирж очиж чадахгүй, ажил эрхлэх боломжгүйд хүрч, цалин, орлогод нь нөлөөлж байна. Олон улс оронд хүмүүс бараа, үйлчилгээг худалдан авах боломжгүй, эсвэл худалдан авахаас татгалзах хандлагатай байгаа бөгөөд энэхүү тодорхойгүй, айдастай нөхцөл байдлын улмаас аж ахуйн нэгжүүд ажилтан авах, бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авах, хөрөнгө оруулалт хийх зэргээ хойшлуулах хандлагатай байна.

Эдийн засгийн төлөв байдал муудаж, хөдөлмөр эрхлэлтийн тоо, чанарын үзүүлэлт маш хурдацтай буурч байна. Нөхцөл байдлын талаарх сүүлийн үеийн таамаглалууд харилцан адилгүй, дээр нь нөхцөл байдлыг дутуу үнэлж байгаа боловч дэлхийн эдийн засаг наанадаж 2020 оны эхний хагаст төдийлөн сайнгүй байх дүр зураг харагдаж байна.<sup>3</sup> Энэ таагүй дүр зураг дэлхийн эдийн засаг хямарч эхэлж буйн дохио юм.

**COVID-19 цар тахлаас ажилчид, тэдний гэр бүлийнхний эрүүл мэндэд үзүүлэх шууд**

<sup>1</sup> 3 сарын 16-ны байдлаар гаргасан үзүүлэлт: Жонс Хопкинсийн Их Сургуулийн Системийн Шинжлэх ухаан, Инженерийн Төв, <https://gisanddata.maps.arcgis.com/apps/opsdashboard/index.html#/bda7594740fd40299423467b48e9ecf6>

<sup>2</sup> Р.Балдвин, В.Дб. Ди Мауро 2020. Covid-19 халдварын үеийн Эдийн засаг. CEPR. <https://voxeu.org/content/economics-time-covid-19>

<sup>3</sup> НҮБХХБХ, <https://unctad.org/en/pages/PressRelease.aspx?OriginalVersionID=548> аас жишээ үзнэ үү.



**нөлөөг хязгаарлаж, дэлхийн эдийн засагт үзүүлэх шууд бус нөлөөллийг бууруулах, даван туулахын тулд олон талт түншлэл, салбар хоорондын уялдааг хангасан бодлогын арга хэмжээг үндэсний болон олон улсын түвшинд яаралтай авах шаардлагатай байна.** Халдварын эрсдэлээс ажилчид, тэдний гэр бүлийнхнийг нэн тэргүүнд хамгаалах ёстой. Халдвар болон эдийн засгийн үйл ажиллагаа хумигдсаны улмаас орлогоо алдаж буй хүмүүсийг хамгаалах зорилгоор эрэлтийг дэмжих арга хэмжээ авах нь эдийн засгийг сэргээхэд ихээхэн ач холбогдолтой. Орлогын эх үүсвэрийг баталгаажуулах нь халдвар тархалтыг бууруулахад хувь нэмрээ оруулах бөгөөд ялангуяа бага орлоготой болон эмзэг бүлгийн ажилчдад учирч болох эрсдэлийг бууруулна.

Бүх нийтийг хамарсан нийгмийн хамгааллын тогтолцоо нь хямралын үед эдийн засаг, нийгмийн тогтворжуулагчийн үүргийг гүйцэтгэж чадах бөгөөд эрэлтэд суурилсан нөхөн сэргээх арга хэмжээ авах, дасан зохицох чадварыг нэмэгдүүлэхэд **институтийн болон бодлогын томоохон шинэчлэл хийх шаардлагатай байна.**

**Засгийн газар, ажилтан, ажил олгогчоос бүрдсэн гурван талт нийгмийн зөвшилцөл нь орон нутгаас олон улсын түвшин хүртэл тогтвортой шийдэл олох, хэрэгжүүлэх гол арга хэрэгсэл болно.** Үүний тулд нийгмийн түншлэгч талууд хүчирхэг, бие даасан, ардчилсан байх ёстой.

Далайцтай, харилцан уялдаатай, эрс шийдэмгий бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь эдийн засгийг улам бүр унах эрсдэлээс хамгаалах боломжтой бөгөөд үүнийг Их Уналт зэрэг хямралын сургамж бидэнд харуулсан.

## **2. Үр нөлөө: COVID-19 хөдөлмөрийн ертөнцөд хэрхэн нөлөөлөх вэ?**

**COVID-19 цар тахал хөдөлмөрийн зах зээлд маш ихээр нөлөөлнө.** Цар тахал одоохондоо ажилчид, тэдний гэр бүлийнхний эрүүл мэндэд шууд нөлөөлж байгаа боловч түүний улмаас бий болох эдийн засгийн сөрөг нөлөө нь хөдөлмөрийн ертөнцийг дараах гурван чиглэлээр хөдөлгөөнд оруулна: 1) Ажлын байрны тоо (ажилгүйдэл, бүрэн бус ажил эрхлэлт); 2) Ажлын чанар (жишээ нь цалин, нийгмийн хамгааллын хүртээмж), 3) Хөдөлмөрийн зах зээлийн таагүй өөрчлөлтөд өртөж болзошгүй зарим бүлгийн ажиллагсад.

**Дэлхий нийтийн ажилгүйдэл, бүрэн бус хөдөлмөр эрхлэлтэд үзүүлэх нөлөө**


**ОУХБ-ын урьдчилсан таамаглалаар уг вирусийн халдвар нь ажилгүйдэл, бүрэн бус**



**хөдөлмөр эрхлэлтийг нэлээд хэмжээгээр нэмэгдүүлэх төлөвтэй байна.** ОУХБ-аас дэлхийн улс орнуудын ДНБ-ий өсөлтөд COVID-19 хэрхэн нөлөөлж буй талаарх хэд хэдэн хувилбарт үндэслэн (Хавсралт I-ийг үзнэ үү) ажилгүйдлийн чиг хандлагыг тооцоолж үзэхэд 2019 онд 188 сая байсан ажилгүйдэл хамгийн багадаа 5.3 сая, хамгийн ихдээ 24.7 саяар өсөхөөр байна.

Харин дундчилж авч үзвэл ажилгүйдэл 13 саяар (өндөр орлоготой орнуудад 7.4 саяар) нэмэгдэнэ. Энэхүү тооцоолол нь төдийлөн бүрэн хэмжээнд хийгдээгүй боловч, бүх үзүүлэлтүүд дэлхийн хэмжээнд ажилгүйдэл нэмэгдэх хандлагатай байгааг харуулж байна. 2008-2009 онд болсон дэлхийн санхүүгийн хямралын улмаас ажилгүйдэл 22 саяар нэмэгдэж байсантай харьцуулан үзэх боломжтой.

**Зураг 1: Дэлхийн эдийн засгийн өсөлт буурснаас ажилгүйдэлд үзүүлэх нөлөөг гурван хувилбараар тооцоолсон нь, дэлхийн хэмжээнд ба орлогын бүлгээр (саяар)**



**Тэмдэглэл:** Зурагт МкКиббин, Фернандо нарын тооцоолсон ДНБ-ий өсөлтийн талаарх гурван хувилбарт үндэслэн ажилгүйдэлд нөлөөлөх нөлөөллийг үзүүлээ (2020). Алдааны шугамууд нь ажилгүйдлийн тооцооллын загварын тодорхойгүй байдлын хязгаарыг харуулж байгаа ба ДНБ-ий өсөлтийн хувилбарыг мөн харуулсан болно.

**Бүрэн бус хөдөлмөр эрхлэлт ч нэлээд өсөх төлөвтэй байна.** Өмнөх хямралын үед тохиолдож байсан шиг хөдөлмөрийн эрэлтэд тулгарч буй хүндрэл, бэрхшээлийн улмаас цалин, ажлын цагийг бууруулах зохицуулалт хийх хандлага ажиглагдаж байна. Хувиараа хөдөлмөр эрхлэгчид эдийн засгийн хямралд төдийлөн эмзэг байдаггүй ч амь зуух эсвэл орлоготой байхын тулд “идэвхгүй” төлөвт шилждэг ба ихэвчлэн албан бус эдийн засагт ажиллагчид үүнд хамаатай. Иймээс хямралын үед албан бус хөдөлмөр эрхлэлт өсөх хандлагатай байдаг. Гэсэн хэдий ч, хүн болон бараа таваарын хөдөлгөөнийг хориглосон байгаа нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, албан бус эдийн засагт ажиллагсдад сөрөг нөлөөтэй байх магадлалтай.



Эдийн засгийн үйл ажиллагаа зогсонги байдалд орж, хөл хөдөлгөөнийг хязгаарласан нь үйлдвэрлэл, үйлчилгээний аль алинд нь нөлөөлж байна. Хамгийн сүүлийн үеийн мэдээгээр авч үзвэл Хятад улсад үйлдвэрлэж буй нэмүү өртөг 2020 оны эхний хоёр сарын хугацаанд 13.5 хувиар буурчээ.<sup>4</sup> Дэлхий нийт болон бүс нутгийн хэмжээнд нийлүүлэлтийн сүлжээ тасалдсан. Үүнд үйлчилгээний салбар, аялал жуулчлал, жижиглэн худалдаа эрхлэгчид илүү эмзэг байна. Дэлхийн худалдаа, аялал жуулчлалын зөвлөлийн урьдчилсан тооцоолсноор 2020 онд олон улсын зорчин ирэгсдийн тоо 25 хүртэл хувиар буурах ба үүнээс улбаалан хэдэн сая хүн ажлын байраа алдах эрсдэлтэй байна.

### Цалин, хөлс болон ажилтай ядууст үзүүлж буй нөлөө

Хөл хорио тогтоох арга хэмжээ, эдийн засгийн үйл ажиллагааны зогсонги байдлын улмаас хөдөлмөрийн нийлүүлэлт буурч байна. Урьдчилсан тооцоогоор буюу 3-р сарын 10-ны байдлаар ажилчид ойролцоогоор **30,000 сарын ажлаа** аль хэдийн алдаад байна.

Хөдөлмөр эрхлэлтэд үзүүлж буй нөлөөллийн улмаар ажилчид орлогоо алдаж байна. Цалин, хөлс, орлогын нийт алдагдал **860 - 3,440 тэрбум ам.долларт** хүрсэн гэсэн тооцоолол гарчээ. Энэхүү цалин, хөлсний алдагдлын улмаас бүтээгдэхүүн, үйлчилгээний худалдан авалт буурах ба энэ нь **бизнесийн тогтвортой байдал**, эдийн засгийн дасан зохицох чадварт сөрөг нөлөөтэй.

**Хүснэгт 1: Цалин, хөлс буурах, ажилтай нэн ядуус болон ядуус нэмэгдэх хандлагатай байна (худалдан авах чадвар өдөрт 3.20 ам.доллаароос бага), 2020**

Орлогын бүлэг	Бага	Дунд	Их
Цалин, хөлс (тэрбум ам.доллар)	-860	-1,720	-3,440
Ажилтай нэн ядуус, ядуус (сая)			
Дэлхий нийт	8.8	20.1	35.0
Бага орлоготой орнууд	1.2	2.9	5.0
Дундаас доогуур орлоготой орнууд	3.7	8.5	14.8
Дундаас дээш орлоготой орнууд	3.6	8.3	14.5

*Тэмдэглэл: Бага болон дунд орлоготой 138 улсад ажилтай ядуус ядуурлын шугамд (худалдан авах чадвар 3.20 доллароос доогуур) тун ойр очно гэж тооцоолсон. Энэ тооцоололд өндөр орлоготой орнуудын ажилтай ядууст нөлөөлөх нөлөөллийг багтаагүй.*

**Ажилтай ядуусын тоо нэмэгдэх төлөвтэй байна.** Эдийн засгийн үйл ажиллагааны зогсонги байдал орлогод нөлөөлснөөр тэднийг ядуурлын шугамд ойр буюу эсвэл түүнээс

<sup>4</sup> Хятадын Статистикийн Үндэсний Хороо, [http://www.stats.gov.cn/english/PressRelease/202003/t20200316\\_1732244.html](http://www.stats.gov.cn/english/PressRelease/202003/t20200316_1732244.html)



доогуур ороход хүргэж байна. Халдварын нөлөөлөл улам ихэссэнээс дэлхий дахины хэмжээнд ажилтай ядуусын тоо 8,8 саяар нэмэгдсэн болохыг хөдөлмөр эрхлэлтийн тоон мэдээ харуулж байна (өөрөөр хэлбэл COVID-19 халдвараас өмнөх үеийн тооцооллоор 2020 онд нийт ажилтай ядуус 14 саяар буурна гэж тооцоолж байсан бол одоо 5.2 саяар буурах төлөвтэй байна). Дунд болон их хувилбараар авч үзвэл 2020 онд COVID-19 халдвараас өмнө тооцоолж байснаас илүү олон буюу 20.1 саяас 35.0 сая хүн ажилтай ядуусын тоонд багтах төлөвтэй.<sup>5</sup>

### Хэн илүү эмзэг вэ?

**Цар тахал болон эдийн засгийн хямрал хүн амын тодорхой бүлгүүдэд маш хүндээр тусч улмаар тэгш бус байдлыг улам гүнзгийрүүлж болзошгүй.**<sup>6</sup> Өмнөх хямралаас авсан сургамж болон COVID-19 цар тахлын тархалтын талаарх мэдээлэлд үндэслэн дараах хүмүүсийг эмзэг бүлэг гэж тодорхойлж болохоор байна:

- Эрүүл мэндийн хувьд тааруу хүмүүс болон ахмад настнууд эрүүл мэндийн хувьд илүү эмзэг байна.
- Залуучуудын ажилгүйдэл, бүрэн бус хөдөлмөр эрхлэлтийн түвшин өндөр байдаг ба хөдөлмөрийн эрэлт багасах нь тэдэнд илүү их эрсдэл дагуулдгийг дэлхийн санхүүгийн хямрал батлан харуулсан. Түүнчлэн ахмад ажилчид эдийн засгийн эмзэг байдалд өртөмхий. MERS тархалтын дараагаар залуучуудаас илүүтэйгээр ахмад ажилчдын ажилгүйдэл, бүрэн бус ажил эрхлэлтийн түвшин нэмэгдэж, ажлын цаг нь буурчээ.<sup>7</sup>
- Хямралд илүү өртөмтгий салбарууд(үйлчилгээний салбар зэрэг)-д буюу эсвэл тахалтай тэмцэх тэргүүн эгнээний ажил, мэргэжлээр (сувилагч зэрэг) ихэвчлэн эмэгтэйчүүд ажиллаж байна. ОУХБ-ын тооцооллоор дэлхийн хэмжээнд хөдөлмөр эрхэлж буй нийт эмэгтэйчүүдийн 58.6 хувь нь, харин эрэгтэйчүүдийн 45.4 хувь үйлчилгээний салбарт ажиллаж байна. Эмэгтэйчүүд нийгмийн хамгаалалд багтах боломж бага байдаг ба сургууль, халамжийн тогтолцооны байгууллагууд хаагдахад халамжийн эдийн засгийн харилцан адилгүй байдалтай нүүр тулдаг (ОУХБ, 2018).<sup>8</sup>
- Хувиараа хөдөлмөр эрхлэгчид, тохиолдлын чанартай ажил эрхлэгчид, цагийн ажил (gig) эрхлэгчид зэрэг нийгмийн хамгаалалд багтаагүй хүмүүс цалинтай болон өвчний чөлөө авах боломжгүй байдаг учир ихээхэн эрсдэлд ордог ба тэд ихэвчлэн конвенцоор баталгаажуулсан нийгмийн хамгаалал болон орлогын баталгааг хангах бусад хамгааллын тогтолцооны гадна байдаг.
- Цагаач ажилчид ажиллаж буй улс руугаа болон ажлын байр луугаа очих, мөн гэртээ харих боломж аль аль нь хязгаарлагдмал болдог учир COVID-19 хямралын нөлөөнд

<sup>5</sup> Дундаас доогуур орлоготой улс орнуудад хэр зэрэг нөлөөлөх нь тодорхойгүй учраас энэхүү тооцоолол бүрэн дүүрэн тодорхойгүй байна. Хэрэв уг вирусийн халдвар эдгээр улс орнуудад ижил байдлаар нөлөөлбөл ажилтай ядууст улам ихээр нөлөөлөх болно.

<sup>6</sup> Жишээ болгон А.Лий, Ж.Чо (2016) нарын бүтээлийг үзнэ үү. Хөдөлмөрийн зах зээл дэх цар тахлыг нөлөө: Солонгосын хөдөлмөрийн зах зээл дэх Ойрх Дорнодын амьсгалын замын халдварын хохирогчийг тогтоох нь. Инт Ж шударга эрүүл мэндийн үйлчилгээ. 2016; 15: 196.

<sup>7</sup> Лий, Чо 2016 (ibid).

<sup>8</sup> ОУХБ (2018) Зохистой хөдөлмөрийн ирээдүйн төлөөх халамж, үйлчилгээний ажил, мэргэжил. ОУХБ, Женев.



илүү эмзэг байна.

### 3. Хариу арга хэмжээ: Хөдөлмөрийн ертөнцөд COVID-19-ийн нөлөөллийг бууруулахад ямар бодлого баримтлах вэ?

Тогтвортой, тохиромжтой хариу арга хэмжээ авахад зохистой хөдөлмөр чухал үүрэгтэйг чухалчилдаг **олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээ нь хямралын үед бодлогын чухал арга хэмжээг боловсруулахад гол үндэс нь болно.** Засгийн газар болон ажилтан, ажил олгогчийн төлөөлөгчдийн байгууллагуудын баталсан эдгээр хэм хэмжээ нь эдийн засгийн өсөлт, хөгжилд хүн төвтэй хандлагад тулгуурладаг ба эрэлтийг хангах, ажилтан, аж ахуй нэгжүүдийг хамгаалахад аль алинд нь чухал бодлогын хөшүүрэг болдог.<sup>9</sup>

**Бодлогын хувьд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь дараах ойрын зорилтуудад чиглэх ёстой: Эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээ болон эдийн засгийн дэмжлэг, туслалцаа нь эрэлт, нийлүүлэлтийн аль алийг хангах ёстой.**

- Юуны түрүүнд, ажилчид, ажил олгогчид, тэдний гэр бүлийнхнийг COVID-19 халдварын эрүүл мэндийн эрсдэлээс хамгаалах ёстой. Ажлын байранд болон олон нийтэд чиглэсэн хамгаалах арга хэмжээ авах, түүнийг улам сайжруулах шаардлагатай ба үүнд олон нийтийн дэмжлэг, хөрөнгө оруулалт шаардагдана.
- Хоёрдугаарт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, орлогын баталгааг хангах, эдийн засаг болон хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг тохируулах цагаа олсон, далайцтай, тохиромжтой бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай. Эдгээр арга хэмжээ нь зөвхөн аж ахуйн нэгжүүд болон ажилчдыг ажлын байр, орлогоо алдахаас хамгаалах бус нийлүүлэлтийн сүлжээний доголдол(ажилчдын бүтээмж буурах зэрэг) болон эдийн засгийн зогсонги байдлыг удаашруулдаг эрэлтийн хямралаас урьдчилан сэргийлэхэд чиглэх ёстой.

**Найдвартай, тогтвортой үр дүнд хүрэхийн дунд бүхий л салбарын бодлогод зорилтот, далайцтай, нэгдсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай.** Энэхүү хямралын цар хүрээ хурдтай тэлж байгаа учраас бүх төрлийн хөндлөнгийн оролцооны шууд болон шууд бус нөлөөлөлд мониторинг хийх нь бодлогын хувьд авч буй арга хэмжээ бий эсэх, тэдгээр нь үүссэн нөхцөлд байдлыг зохицуулж чадаж буй эсэхийг тодорхойлоход чухал үүрэгтэй.

**Итгэлцэл, зөвшилцлөөр дамжуулан итгэл найдвар төрүүлэх нь бодлогын арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхэд маш чухал.** Ялангуяа нийгэм хурцадмал байдалтай,

---

<sup>9</sup> Хавсралт II-т Их уналт, SARS/MERS зэрэг хямралаас авсан гол сургамжуудыг тоймлон үзүүлэв.





байгууллагад итгэх итгэл сул байгаа үед нийгмийн зөвшилцөлд хүндэтгэлтэй хандах болон итгэл төгс байдал нь ажил олгогч, ажилтан, Засгийн газартай хамтын ажиллагааны харилцан итгэлцлийн үндэс болдог. Аж ахуйн нэгжийн түвшинд ч нийгмийн зөвшилцөл хамгийн чухал.

**Бодлогын хүрээ: Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээнд тулгуурлан COVID-19 халдварын эсрэг арга хэмжээ авч хэрэгжүүлэх гурван гол тулгуур**



ДЭМБ-ын зөвлөмж, удирдамжид дагуу COVID-19 халдварын шууд нөлөөллийг бууруулахын тулд **ажилчдыг ажлын байран дээр нь хамгаалах нь**:<sup>10</sup>

- ХАБЭА-н хороо зэрэг ажил олгогч болон ажилтан, тэдгээрийн төлөөллүүд зөвшилцөн хүн хоорондын зай барих, хамгаалах хэрэгслээр хангах (ялангуяа хүнтэй байнга харилцаж ажилладаг эрүүл бөгөөд үйлдвэрчний эвлэлийн гишүүд, сайн дурынхан болон бусад ажилчдыг) зэрэг ХАБЭА-н холбогдох арга хэмжээ, эрүүл ахуйн дүрэм журам, хөдөлмөр зохион байгуулалтын хэлбэр(мэдээлэл түгээх, ойлголт нэмэгдүүлэх кампанит ажлууд)-ийг шинэчлэн боловсруулах;
- Зайнаас ажиллах зэрэг хөдөлмөр зохион байгуулалтын уян хатан зохицуулалтыг дэмжих;
- COVID-19 халдвартай холбогдуулан ялгаварлан гадуурхахаас урьдчилан сэргийлэх;
- Даатгалд хамрагдаагүй ажилчид, тэдний гэр бүлийнхнийг хамруулсан хамтын

<sup>10</sup> <https://www.who.int/docs/default-source/coronaviruse/covid-19-sprp-unct-guidelines.pdf>





санхүүжилттэй эрүүл мэндийн үйлчилгээг бүх нийтэд хүртээмжтэй болгох;

- Өвчтэй, хөл хорионд, эсвэл хүүхэд, өндөр настан, гэр бүлийн бусад гишүүнээ асран халамжилж буй хүмүүсийн орлогын баталгааг хангах зорилгоор хамтын санхүүжилтээс цалинтай чөлөө, өвчний тэтгэмж, эцэг эхийн болон асран халамжлах үүргээ биелүүлэх чөлөө олгох боломжийг нэмэгдүүлэх.

Эдийн засгийн үйл ажиллагааг тогтворжуулахад чиглэсэн эдийн засаг, хөдөлмөр эрхлэлтийн бодлого боловсруулж **эдийн засаг, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг сэргээх.**

- Бага орлоготой хүмүүс болон бичил болон ЖДҮ эрхлэгчдэд төрөөс санхүүжилт олгох, татварын хөнгөлөлт үзүүлэхийн зэрэгцээ ажилгүйдлийн тэтгэмж зэрэг зорилтот мөнгөн шилжүүлэг, автомат тогтворжуулагчийн үүрэг гүйцэтгэгч нийгмийн хамгааллын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- Валютын бодлого авч хэрэгжүүлэх (хүүг бууруулах, бодлогын хүүг хойшлуулах, төлбөрийн чадварыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх);
- Аж ахуйн нэгжүүд, ялангуяа бичил болон ЖДҮ эрхлэгчдийг дэмжих зорилгоор тодорхой салбаруудад зорилтот зээл олгох, санхүүгийн дэмжлэг үзүүлэх. COVID-19 халдварын эсрэг дасан зохицох чадварыг сайжруулахын тулд эрүүл мэндийн салбарт хөрөнгө оруулах төдийгүй зохистой ажлын байр бий болгох боломжийг санал болгох нь чухал.

Шууд бус сөрөг нөлөөнд өртсөн (үйлдвэр хаах, өртгийн сүлжээ тасалдах, хөдөлгөөн хорих, олон нийтийн арга хэмжээг цуцлах зэрэг) аж ахуйн нэгж, ажилчдыг хамгаалахын тулд **хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, орлогын баталгааг хангах.**

- Одоогийн нийгмийн хамгааллын тогтолцооны хүрээнд болон эсвэл нөхцөл байдалд уялдуулан албан бус салбарын ажилчид, тохиолдлын болон улирлын чанартай ажил эрхлэгч, цагаач ажилчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд (ажилгүйдлийн тэтгэмж, нийгмийн тусламж үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний хөтөлбөр зэрэг) мөнгөн тэтгэмж олгох;
- Ажлын цагийг богиносгох/ажилгүйдлийн тэтгэмж хэсэгчилж олгох зэрэг ажлын байрыг тогтвортой байлгах хөтөлбөр хэрэгжүүлэх, мөн цалингийн татаас [цалингаас авах татвар, нийгмийн даатгалын шимтгэлээс түр хугацаанд чөлөөлөх], ажилтанд цалинтай чөлөө олгох, одоо эдэлж буй эрх, боломжийг нэмэгдүүлэх, сургалтад хамрагдах чөлөө, тэтгэлэг, бусад холбогдох тэтгэмжийн урамшуулал олгох зэргээр аж ахуйн нэгжүүдэд цаг зуурын дэмжлэг үзүүлэх;
- Бизнесийн тогтвортой байдал, ялангуяа, бичил болон ЖДҮ эрхлэгчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг дэмжих зорилгоор санхүү/татварын хөнгөлөлт, орлогыг тогтворжуулах богино хугацааны арга хэмжээ (татаас, төлбөрийн чадвартай холбоотой бэрхшээлийг даван туулахад шаардлагатай зээл/дахин санхүүжилт) авч хэрэгжүүлэх.



## 4. Улс орнууд ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж байна вэ?

Улс орнууд аль хэдийн арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. COVID-19 халдварын тархалтын эхэн үед зарим улс орон уг халдварын эдийн засаг, хөдөлмөрийн зах зээл дэх сөрөг нөлөөллийг бууруулах дараах гурван чиглэлээр бодлогын шийдэмгий арга хэмжээ авч хэрэгжүүлсэн: ажилчдыг ажлын байранд хамгаалах; эдийн засаг болон хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлэх; хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, орлогын баталгааг хангах (Хүснэгт 3).<sup>11</sup>

### Хүснэгт 3: COVID-19 халдварын эсрэг авч хэрэгжүүлсэн арга хэмжээний жишээ

Ажилтнуудыг  
ажлын байран  
дээр нь  
хамгаалах

#### Зайнаас ажиллах зэрэг хөдөлмөр зохион байгуулалтын арга хэмжээ авах:

Нэлээд хэдэн улс оронд үндэсний хэмжээнд эсвэл байгууллагын түвшинд **зайнаас ажиллуулах, ажлын цагийг уян хатан зохион байгуулах** зэрэг арга хэмжээ авч байна. Итали, Японд зайнаас ажиллахад нь дэмжлэг болгож санхүүгийн дэмжлэг үзүүлэх, дүрэм журмаа хялбаршуулах зэрэг арга хэмжээ авсан.

#### Цалинтай өвчний чөлөө авах боломжийг нэмэгдүүлэх:

Нэлээд хэдэн улс эрүүл мэндийн хувьд сайнгүй байгаа болон хөл хорионд байгаа ажилчдад **цалинтай өвчний чөлөө** олгох боломжтой болжээ. Хятадын Засгийн газар хөл хорио болон өвчний улмаас ажлаа хийх боломжгүй байгаа ажилчдад цалинг нь олгох тухай зааварчилгаа өгсөн. Ирланд, Сингапур, Өмнөд Солонгост хувиараа хөдөлмөр эрхлэгчид цалинтай чөлөө болон цалинтай өвчний чөлөө авах боломжтой болж байгаа бол Нэгдсэн Вант улсад өвчин нь оношлогдсон эсвэл өөрийгөө тусгаарлаж байгаа ажилчдад өвчний үед олгох тэтгэмжийг дөрөв дэх биш эхний өдрөөс олгохоор болсон.

#### Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй(ХАБЭА)-н зөвлөгөө:

Ажил олгогчид, ажилтнуудад лавлах утас, зориулалтын веб сайт

<sup>11</sup> Бодлогын арга хэмжээний хувилбар маш хурдан өөрчлөгдөж байгаа ба үйл ажиллагааны хөрөнгө оруулалт ч байнга шинэчлэгдэнэ.



болон мэдээллийн хуудас тарааж **ажлын байран дээрх ХАБЭА-н арга хэмжээ, хариу арга хэмжээний талаарх зөвлөгөө** өгч байна. Японы Бизнесийн Холбоо (Keidanren) гишүүн компаниудаасаа COVID-19 тархалтын эсрэг ажлын байран дээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар санал асуулга авч байгаа бол Японы Үйлдвэрчний эвлэлийн холбоо (JTUC-RENGO) тусгай лавлах утас шинээр нээн ажиллуулж байна.

#### **Ялгаварлан гадуурхахаас урьдчилан сэргийлэх:**

**Гутаан доромжлох, ялгаварлах, гадуурхах** үзэгдэл улс орнуудад өөр өөр хэлбэрээр илэрч байна. Японд эрүүл мэндийн салбарын ажилтнууд COVID-19-тэй холбоотой дарамтад орсон гэж мэдэгдсэн бөгөөд энэ асуудлыг шийдвэрлэх зорилгоор Хууль зүйн яам дээрэлхэх, дарамтлах асуудлаар лавлах утас руу холбогдох линк бүхий веб хуудас ажиллуулж байна.

#### **Бусад арга хэмжээ:**

Сургууль, хүүхэд харах үйлчилгээний байгууллага хаагдчихсан байгаа бараг бүх улсуудад **ажлаа хийж буй эцэг эхчүүдэд хүүхдээ асрахад нь дэмжлэг үзүүлэх** зэрэг бусад арга хэмжээ авч байна. Японы Үйлдвэрчний эвлэлийн холбоо (JTUC-RENGO) сургууль хаагдсан учраас ажилтай эцэг эхчүүдийг дэмжихийн тулд хичээлийн дараах хүүхэд харах үйлчилгээнд дэмжлэг үзүүлж байна, мөн ажилтнууд нь хүүхэд асрагч авах хэрэгцээтэй аж ахуйн нэгжүүдэд дэмжлэг үзүүлэхээр мэдэгдээд байна. Италид мөн ийм зорилгоор цэцэрлэг, сургууль ажиллахгүй байгаа үед ээлжийн амралтаа авч буй ажилтнуудад эрхийн бичиг олгож байна. Германы зарим улсуудад хүүхэд асрах үйлчилгээ эрхлэх хүсэлтэй хүмүүст Засгийн газраас нөөцөөр хангахыг санал болгож байна.

#### **Зорилтот санхүүгийн бодлого, валютын уян хатан зохицуулалт:**

Австрали, Канад, Шинэ Зеланд, Нэгдсэн Вант улс болон АНУ-ын Төв банк **хүүг** тэглэсэн. Өмнөд Солонгосын засгийн газар 2020 онд 20 их наяд воны төсөвтэй тусгай Дэмжлэгийн Багц гаргаж байгаага мэдэгдсэн. Итали татвар, нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлж, орон сууцны зээлийн урьдчилгаа төлбөрийн төлөх хугацааг сунгажээ.



### **Эрүүл мэнд зэрэг тодорхой салбаруудад зээл, санхүүгийн дэмжлэг үзүүлэх:**

Зарим улсууд **тодорхой салбаруудад санхүүгийн дэмжлэг үзүүлэхээ** мэдэгдсэн. Хятадын Засгийн газар маск, эрүүл мэндийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй аж ахуйн нэгжүүдэд 300 тэрбум юанийн зээлийн хүүгийн татаас олгох болсон. Нэгдсэн Вант улс Үндэсний Эрүүл Мэндийн Үйлчилгээ(ҮЭМҮ)-нд 5 тэр бум фунт хуваарилсан бол Ирландын Засгийн газар Эрүүл мэндийн Үйлчилгээний Байгууллагад 435 сая евро хуваарилсан. Өмнөд Солонгост аялал жуулчлал болон бусад нөлөөнд автаж буй салбаруудыг тодорхойлж, тэдгээрт олгох татаасыг нэмэгдүүлж, урт хугацааны дэмжлэг үзүүлэх болсон. Франц, Герман улсууд халдварын нөлөөнд автаж буй бүх салбаруудад дэмжлэг үзүүлэхээр өргөн хүрээний арга хэмжээ авахаа мэдэгдсэн. Герман улс аж ахуйн нэгжүүдэд “бүх талаар” дэмжлэг үзүүлэхээ зарлав.

**Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, орлогын баталгааг хангах**

### **Ажлын ачааллыг бууруулах, нөхөн олговор олгох:**

Франц, Герман (Kurzarbeit), Итали, Нидерландад ажилчдын ажиллаагүй цагт нөхөн олговор олгох зэрэг **цалинтай ажлын цагийг бууруулах/ажилгүйдлийн тэтгэмж хэсэгчлэн олгох** арга хэмжээг өргөжүүлж, хялбаршуулсан арга хэлбэр хэрэглэж байна.

**Ажлын байрыг хадгалах** арга хэмжээг бусад арга хэлбэрээр баталгаажуулж, дэмжиж байна. Хятадын засгийн газраас цагаач ажилчдыг өвчтэй, эсвэл хязгаарлалтад байгаа тохиолдолд хөдөлмөрийн гэрээг цуцлахгүй байх талаар мэдэгдэл гаргасан.

Цөөн хэдэн улс ажилгүйдлийн тэтгэмж олгох арга хэмжээг өргөжүүлж байна. Филиппиний Нийгмийн хамгааллын Тогтолцоо(НХТ)-ны хүрээнд үйлдвэр хаагдах, бизнес нь зогссоноос ажилгүй болж болзошгүй 30,000 – 60,000 ажилтанд ажилгүйдлийн тэтгэмж олгохоор төлөвлөжээ.



Зарим улс орлогын баталгааг хангах, өсөн нэмэгдэж буй эрэлтийг хангахын тулд **нийгмийн туслалцааны тэтгэмж**, мөн бусад хэлбэрийн бэлэн мөнгөний тэтгэмж олгож байна. Хонконг, Хятадад насан хүрсэн иргэддээ 1,280 долларын нэг удаагийн бэлэн мөнгөний тусламж үзүүлэхээр болсон ба энэ нь эдийн засгийг 1 хувиар нэмэгдүүлнэ гэж үзэж байна.

**Санхүү/татварын хөнгөлөлт (аж ахуйн нэгжүүдэд мөн адил):**

Нэлээд хэдэн улс **санхүүгийн дэмжлэг үзүүлж, татварын хөнгөлөлт** үзүүлж байна. Нэгдсэн Вант улс ЖДБЭ-дэд зээл, хугацаа хэтэрсэн зээлийн дүнгийн 80 хувьд нь батлан даалт гаргасан ба жижиг бизнесийг дэмжих зорилгоор орон нутгийн удирдлагын байгууллагуудад 2.2 тэрбум фунтийн нэмэлт санхүүжилт олгохоор болжээ. Өмнөд Солонгост жилд 60 сая вон болон түүнээс бага ашиг орлоготой бизнесийн байгууллагыг НӨАТ-аас чөлөөлөх, жижиг худалдаа наймаа эрхлэгчид, ЖДБЭ-дийг дэмжихээр Санхүүгийн Тусгай Дэмжлэг олгох хөтөлбөрөө улам өргөжүүлэхээ мэдэгдсэн. Францад татварын хөнгөлөлтийн хүрээнд ямар нэг үндэслэл, аж ахуйн нэгжийн хэлбэр, торгуультайгаас үл хамааран бүх компаниудын 2020 оны 3-р сард шимтгэл, татварын төлбөрийг хойшлуулахаар шийдвэрлэжээ. Вирусийн нөлөөгөөр хямралд орсон компаниуд нийгмийн болон татвартай холбоотой төлбөрүүдээ хойшлуулах боломжтой төдийгүй маш хүнд эвсэл хүнд байдалд байгаа тохиолдолд татварын хөнгөлөлт эдлэх боломжтой болсон байна.

Эдгээр арга хэмжээ нь цар тахлыг даван туулах, онцгой нөхцөл байдлын улмаас үүссэн нөхцөл байдалд хариу арга хэмжээ авах, аажмаар нөхөн сэргээх арга замыг олж илрүүлэхэд дэмжлэг болох нь эргэлзээгүй бөгөөд цаашид ч илүү их хэрэгцээ гарч ирэх нь тодорхой байна. Өнгөрсөнд тохиолдсон хямрал болон COVID-19 халдварын нөхцөлд байдалд хэтэрхий хожуу арга хэмжээ авч буй улс орнуудын нөхцөл байдлаас авч үзвэл онцгой байдалд бэлэн байх, эрт хариу арга хэмжээ авах нь чухал болохыг харуулж байна.



## Хавсралт I: Хөдөлмөрийн ертөнц дэх COVID-19 цар тахлын нөлөөллийг тооцоолох нь

ОУХБ нь улс орнуудын хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийг цуглуулдаг бөгөөд мэдээллээ гаргах боломжгүй улс орнуудын хувьд жил жилийн хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүдийг нь тооцоолоход эконометрийн хэд хэдэн загвар ашигладаг. Зарим мэдээллээ гаргаж чадахгүй байгаа улс орнуудын хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүдийг тооцоолж байгаагийн гол зорилго нь жил бүр бүс нутаг, дэлхий нийтийн нэгдсэн үзүүлэлтийг тооцоолж, тэнцвэртэй суурь мэдээлэл гаргах зорилготой. ОУХБ энэ мэдээлэлдээ тулгуурлан дэлхийн болон бүс нутгийн хөдөлмөрийн зах зээлийн гол үзүүлэлтүүдийг ирээдүйн чиг хандлагын хамт тодорхойлдог.

COVID-19 цар тахал эдийн засгийн өсөлт(ДНБ)-д нөлөөлөх нөлөөлөлд хийсэн дүн шинжилгээнд үндэслэн хөдөлмөр эрхлэлт/ажилгүйдлийг тооцох хэд хэдэн хувилбаруудыг гаргаж ирэх боломжтой. Дэлхий нийтийн холимог DSGE/CGE загвар дахь эрэлт, нийлүүлэлтийн эрсдэлийн хамрах хүрээг тогтоосон МкКиббин, Фернандо (2020)<sup>12</sup> нарын санал болгосон хөдөлмөрийн зах зээл дэх нөлөөллийг тодорхойлдог ОУХБ-ын загварт хэрэглэсэн эдийн засгийн тооцоолоор бүх дэлхийн бүх улс жилийн турш цар тахалтай тэмцэх болно.<sup>13</sup> Энэхүү судалгаа нь вирусийн нөлөөллийн давуу талуудад үндэслэн боломжит гурван хувилбарыг санал болгож байна (бага, дунд, их). Эдгээр хувилбарууд ажилгүйдлийн талаарх дараах гурван төрлийн тооцоолол гаргаж ирнэ:

- ДНБ-ий өсөлт ойролцоогоор 2 хувиар буурна гэж үзэх “бага” хувилбар: Дэлхийн ажилгүйдлийн түвшин 5.3 саяар нэмэгдэж, тодорхойгүй байдал 3.5 - 7 саяд хүрнэ.<sup>14</sup>
- ДНБ-ий өсөлт 4 хувиар буурна гэж үзэх “дунд” хувилбар: Дэлхийн ажилгүйдлийн түвшин 13 саяар (өндөр орлоготой улс орнуудад 7.4 сая) нэмэгдэж тодорхойгүй байдал 7.7-аас 18.3 саяд хүрнэ.
- COVID-19 сүйрүүлэх нөлөөтэй гэж үзэх “их” хувилбараар ДНБ-ий өсөлт 8 орчим хувиар буурна: Дэлхийн хэмжээнд ажилгүйдлийн түвшин 24.7 хувиар өсөж, тодорхойгүй байдлын хамрах хүрээ 13 саяас 36 саяд хүрнэ.

<sup>12</sup> МкКиббин, Р.Фернандо (2020) Дэлхийн макро эдийн засаг дахь COVID-19 халдварын нөлөө: Долоон хувилбар. <https://www.brookings.edu/research/the-global-macroeconomic-impacts-of-covid-19-seven-scenarios/>

<sup>13</sup> Зохиогчид бүх улсад нөлөө үзүүлж байна гэж үзсэн. ДНБ-ий өсөлтөд нөлөөлөх нөлөөлөл улс орнуудад ямар нэг байдлаар өөр өөр ба ялангуяа өндөр болон дунд орлоготой улсуудад ялгаатай байна, гэвч учрах эрсдэл нь ерөнхийдөө ижил.

<sup>14</sup> Энэхүү тодорхойгүй байдал нь COVID-19 халдварын хөдөлмөр эрхлэлт дэх нөлөөллийг ДНБ-ий өсөлт дэх нөлөөллийг тооцох хувилбарын алдааны хэмжээнээс шалтгаалж байна.



## Хавсралт II: Өнгөрсний сургамж: Хямралаас авсан холбоотой гол сургамжууд

Энэ удаагийн цар тахал өвөрмөц онцлогтой хэдий өмнөх эдийн засгийн хямрал (тухайлбал дэлхийн санхүүгийн хямрал) болон тахал (шувууны болон гахайн ханиад, SARS, MERS, Эбола вирусийн халдвар – ЭВХ) зэрэг нь хямралыг даван туулах, нөхөн сэргээх бодлого боловсруулахад хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, нийгмийн түншлэл чухал байр суурьтай байдаг талаар **бидэнд сургамж үлдээжээ.**

**Бодит, байнгын, цаг үеийн, ил тод мэдээлэл нь зөвхөн цар тахалтай тэмцэх төдийгүй** ажлын байр зэрэг эдийн засаг, нийгмийн хүрээний бүхий л түвшинд **тодорхойгүй байдлыг багасгаж, итгэл найдвар төрүүлэхэд маш чухал юм.** Итгэл найдвар буурснаар хэрэглэгчдийн худалдан авалт төдийгүй бизнесийн хөрөнгө оруулалтад нөлөөлж эдийн засаг удааширч, нөхөн сэргээх арга хэмжээнд хүндрэл учирдаг.

**Ажлын байр нь** халдварын тархалтыг бууруулахад чиглэсэн урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ авах зэрэг **хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх мэдээлэл түгээх, харилцаа холбоо тогтоох, цаг үеийн талаар мэдрэмжтэй байлгахад тохиромжтой газар юм.** Тиймээс ялангуяа хямралд хамгийн ихээр өртөж буй салбаруудад ажлын байрыг хадгалж үлдсэнээр уг халдварын нийгэм, эдийн засгийн нөлөөг бууруулахад тустай. Ажилчид, ажил олгогчид хамтран гишүүдийнхээ чадавх бэхжүүлэх, урьдчилан сэргийлэх, ойлголт нэмэгдүүлэх арга хэмжээ авах, холбогдох олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээнд нийцсэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэмжээг мөрдүүлэх боломжтой.

**Жижиг гэхээс илүүтэй** их хэмжээний нөөц (про-актив санхүүгийн бодлого зэрэг) болон дэвшилтэт бодлогын шийдэл (зорилтот бүлгүүдэд бэлэн мөнгө тараах хөтөлбөрийн олон шинэ хувилбар) ашигласан **далайцтай хөндлөнгийн оролцооны арга хэлбэрүүд өөрчлөлтийг бий болгоно.** Хямралд өртсөн хүн амын амьжиргааны түвшнийг тогтвортой байлгах, эрэлтэд нийцсэн нөхөн сэргээх арга хэмжээг урамшуулан дэмжих нь маш чухал.

**Хамгийн их өртөж, анхаарал хандуулах шаардлагатай ажиллах хүчний тодорхой бүлгүүд.** Их Уналтын үед ажиглагдсанаар, залуучууд болон 55-аас дээш насныхны хөдөлмөр эрхлэлтийн статусыг хадгалахад ихээхэн дэмжлэг шаардлагатай байдаг ажээ.<sup>15</sup> Эрүүл мэндийн онцгой байдлын үед хүн амын зарим бүлэг ихээхэн эмзэг байдгийг ЭВХ бидэнд ойлгуулсан (тухайлбал, асрах, халамжлах үүрэгтэй хүлээдэг эрүүл мэндийн

<sup>15</sup> А.Лий; Ж.Чо. Хөдөлмөрийн зах зээл дэх цар тахлын нөлөө: Солонгосын хөдөлмөрийн зах зээл дэх Ойрх Дорнодын амьсгалын замын халдварын хохирогчийг тогтоох нь. Эрүүл мэндийн шударга үйлчилгээ олон улсын сэтгүүл. 2016;





салбарын ажилтнууд болон эмэгтэйчүүд).

**Хувиараа хөдөлмөр эрхлэлт зэрэг хөдөлмөр эрхлэлтийн зарим төрөлд онцгой анхаарал хандуулах нь** нөхөн сэргээх үйл ажиллагааны **үндэс юм**. Өнгөрсөн хугацаанд бидэнд тохиолдсон эрүүл мэнд, байгалийн гамшиг зэрэг хямралын үед эрүүл мэнд, ус, ариун цэвэр, эрүүл ахуйн (WASH) дэд бүтэц, үйлчилгээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн хөрөнгө оруулалт хийх нь ажлын байр нэн даруй бий болгох чухал арга болж байв. Ур чадвар хөгжүүлэх, аж ахуй эрхлэхийг дэмжих бодлогууд нь ажилгүйдлийн нөлөөллийг тодорхой хэмжээгээр бууруулж байв.

**Нийгмийн хамгааллын тогтолцоо, нийгмийн үйлчилгээнд чиглэсэн дэд бүтэц нь** онцгой нөхцөл байдлын үед шуурхай арга хэмжээ авах, хямралаас үүдэлтэй цаашид учрах нөлөөг бууруулж **нийгмийн дасан зохицох чадварыг нэмэгдүүлдэг**. Үр дүн бүхий нийгмийн хамгааллын тогтолцоо нь хүчирхэг эдийн засаг, нийгмийн тогтворжуулагч болдог ба ялангуяа хямралаас өмнө ийм тогтолцоо бүрдсэн бол илүү үр дүнтэй. Нийгмийн хамгааллын тогтолцоо нь хямралын үеийн эрэлтийг зохицуулахад маш чухал үүрэгтэй нь олон талаар батлагдсан. Баруун Африкийн зарим хэсэгт тархсан ЭВХ-ын нөхцөл байдал нь цар тахлын үед нийгмийн хамгааллын тогтолцооны хүрээнд арга хэмжээ авч хэрэгжүүлж чадахгүй бол эмзэг байдлыг улам хүндрүүлж ядуурал, ажилгүйдэл, албан бус байдлыг нэмэгдүүлдэг болохыг харуулсан.

**Бүх шатанд бэлтгэлтэй байх нь нөлөөллийг бууруулах, дасан зохицох чадварыг нэмэгдүүлэх,** ажлын байр, аж ахуйн нэгжүүд, амьжиргааг хамгаалахад **чухал үүрэгтэй**. Өмнөх туршлагаас харахад бизнесийн тогтвортой байдлын төлөвлөгөө нь тодорхойгүй ирээдүйг баримжаалах; эрсдэлийг тодорхойлох, хариу арга хэмжээ авах замаар бизнесийн тогтвортой байдлыг дэмжих; бизнесийн тэргүүлэх чиглэл, гол бүтээгдэхүүн, үйлчилгээг ойлгох; хариу арга хэмжээ авах төлөвлөгөө боловсруулах; хямралын нөлөөллийг багасгахад чиглэсэн арга хэмжээ авах, ажлын байр, ажилтнууд хамгаалалтад байгаа эсэх болон бэлэн байдалд байгаа эсэхийг баталгаажуулахад чухал болох нь харагдсан.

**Засгийн газар, нийгмийн түншүүдийн тогтсон, байнгын зөвшилцөл** нь аж ахуйн нэгж, салбар, түүнчлэн макро эдийн засгийн түвшинд **үр дүнтэй хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэйг** түүхэн эдийн засгийн хямрал харуулсан. Засгийн газар хямралын шалтгаан, үр дагаврыг тодорхойлох төдийгүй нэг талт арга хэмжээ авч нийгмийн тогтвортой байдлыг хангах, нөхөн сэргээхэд анхаардаг. Нийгмийн зөвшилцөл нь хямралын үеийн тэнцвэртэй менежмент, нөхөн сэргээх арга хэмжээг түргэтгэх орлуулж болшгүй чухал хэрэгсэл төдийгүй нөхцөл байдлын өөрчлөлттэй холбоотой хамгийн чухал засаглалын арга хэрэгсэл юм. Засгийн газартай тохиролцсон харилцааны сувгууд, урт хугацааны хэлэлцүүлгүүд нь ажилчны болон ажил олгогчийн төлөөллийн байгууллагууд тогтвортой, ажлын байраа хадгалах замаар аж ахуйн нэгжийн бүтцийг дахин хуваарилах боломж олгоно.